

ОУДБ-ын хууль тогтоомжийг өдөр тутмын үйл  
ажиллагаандаа мөрдөн ажиллах тухай  
Хэрэгжилтийг хянах болон ОУДБ-аас зохион  
байгуулж буй Аудитын шалтгалтын тухай

1

*Далбааны, Боомтын, Эргийн Улсын Үүрэг хариуцлага,  
Хуулийн дагуу хүлээх хариуцлагын хэрэгжилт, биелэлтийг  
хэрхэн хянах тухай*

## Далайн салбарын конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэх тухай

Конвенцийг үр өгөөжтэй байлгах буюу илүү үр ашигтай хэрэгжүүлэхийн тулд Гишүүн улс бүр дараахь арга хэмжээг авсан байна. Үүнд:

- Конвенцид нэгдэж орно.
- Холбогдох Үндэсний хууль тогтоомжийг конвенцтэй уялдуулан боловсруулж, батлуулна.
- Үндэсний хууль тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлж хэвшинэ.
- Хэрэгжилтийг тогтмол хянаж, шаардлагатай үед албадан хэрэгжүүлнэ.
- Тайлан мэдээ хүргүүлэх үүргийг хангаж ажиллана. (конвенцийн шаардлагын дагуу ийм мэдээ гаргаж, хүргүүлэх үүргийг хүлээсэн тохиолдолд)

## Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ерөнхий зарчим

- Одоо мөрдөгдөж байгаа хуулиа хянаж үзнэ;
- ОУДБ-ын хууль тогтоомжид орж буй нэмэлт өөрчлөлтийг тогтмол дагаж хяналт тавина.
- ОУДБ-ын хурал зөвлөгөөнд байнга оролцож, тухайн асуудлын хүрээнд өрнөж буй үйл ажиллагаанд анхаарал хандуулах ба шаардлагатай өөрчлөлт бүрийг дагуу холбогдох хууль тогтоомжийг өөрчилж, шинээр боловсруулан батлуулна.
- Эдгээр хуулийг зөрчсөн тохиолдолд албадан хэрэгжүүлэх эрх мэдлээр хангагдсан байх шаардлагатай.
- Үүрэг хариуцлагын тогтолцоог сайтар хуульчилж хоорондоо харшлахгүй байхад анхаарна.
- Зохих сонирхогч талуудыг хууль боловсруулах үйл ажиллагаанд татан оролцуулсан байна.
- Шинээр гарсан конвенцийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг эхлэхээс өмнө хууль эрх зүйн орчин болон хэрэгжүүлэхтэй холбоотой бэлтгэл ажил хийгдсэн байхад анхаарч ажиллана.

## ГИШҮҮН ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

- Гишүүн орон бүрийн хуулийн бүтэц хоорондоо ялгаатай байдаг.
- Ихэвчлэн хоёр шатлалтай хуулийн бүтэцтэй байх ба энэ нь уян хатан байлгах, үр ашигтай хэрэгжүүлэхэд илүү дөхөмтэй байна.
  - Гол хууль - Хууль, Журам, Тогтоомж
  - Дагалдан гарах хууль тогтоомж – журам, тушаал, дүрэм зэрэг бусад зохицуулах эрх зүйн акт

# ГИШҮҮН ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

Үндсэн хууль тогтоомж нь ихэвчлэн Хууль тогтоох байгууллага буюу Их хурлаар батлагдсан байдаг байна.

Дагалдан гарах хууль тогтоомжийг Сайд болон Засгийн газрын аливаа агентлагаас эх хууль буюу Үндсэн гол хууль тогтоомжийн хүрээнд боловсруулан батлагдсан байх ба эдгээр нь дараахь үндсэн шинжийг агуулна.

- Тогтмол шинэчлэгдэн өөрчлөгддөг
- Техникийн нарийвчлал бүхий мэргэжлийн шинж чанарыг агуулсан
- ОУДБ-ын шийдвэр, гарын авлага болон нэмэлт өөрчлөлт бүхий бичвэрийг агуулсан
- ОУДБ-ын заавал хэрэгжүүлэх хууль дүрэм болон гарын авлагын заалтыг нэмэлт хууль болгон ишилж оруулсан.

## ГИШҮҮН ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

Гишүүн орнууд ихэвчлэн дараахь хэлбэрүүдийг ашиглан үндэсний хууль тогтоомжоо бүрдүүлсэн байдаг. Үүнд:

- ▶ Гишүүн орны зүгээс заавал биелүүлэх ёстой ОУДБ-ын шаардлагыг салбарын гол хуулиндаа шууд тусгадаг.
- ▶ Үндсэн гол салбарын хуулиндаа тухайн конвенцийн заалт (нэмэлт өөрчлөлт орсон байдлаар)-ыг мөрдөхөөр холбоос оруулдаг.

Тэмдэглэл: Дээрх нөхцлийн аль нь ч байсан хариуцлагын тогтолцоо тусгагдсан байх шаардлагатай.

# ХУУЛИЙН ШАТ ДАМЖЛАГА

**Алхам 1:** Конвенцийг судлах & хэрэгжүүлэх шаардлагыг тодорхойлох (... сар?)

1. Нэгдэж орсоноор хүлээх үүрэг хариуцлага, даган гарах үр дагаврыг тодорхойлох;
2. Хүний нөөц, ажилтнуудыг тусгайлан сургалтанд хамруулах шаардлага байгаа эсэхийг тодорхойлох;
3. Зөвлөмж бэлтгэх;
4. Нэгдэж орох үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах зөвшөөрлийг удирдлагаас авах.

**Алхам 2:** НЭГДЭЖ ОРОХ & ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ (... сар?)

1. Ажлын хэсгийг байгуулах
2. Бэлтгэл ажлын хуваарь гаргах
3. Шаардагдах хууль тогтоомжийн хэлбэр & түүнийг бэлтгэх хугацааг тодорхойлох
4. Нэгдэж орох зөвшөөрөл болон & хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулах, зөвшөөрөл авах

**Алхам 3:** Зөвлөлдөх, зөвшилцөх (хэрэв шаардлагатай бол) Эрх ашиг нь хөндөгдөж болох талууд болон Засгийн газрын бусад агентлагуудтай зөвшилцаж дэмжлэгийг нь авах

## ХУУЛИЙН ШАТ ДАМЖЛАГА

### **Алхам 4:** Зөвшөөрөл авах (? сар)

1. Сайд болон Засгийн газарт танилцуулга бэлтгэх;
2. Сайд болон Засгийн газрын зөвшөөрлийг авмагц бусад холбогдох талуудад мэдээлэх;

### **Алхам 5:** Хуулийн төслийг бэлтгэх (? сар)

1. Хуулийн төслийг бэлтгэж холбогдох зөвшөөрлийг авах;
2. Хуулиудад нэмэлт өөрчлөлт орохоор бол (if a Bill required), бэлтгэж Засгийн газрын холбогдох нэгжээс зөвшөөрөл авах, Парламентад оруулахаар бэлтгэх;
3. Хууль батлагдахад бэлэн болсон эсэхийг шалгах;
4. Төрийн мэдээлэл зэрэг хууль батлагдсаныг албан ёсоор мэдээлэх хүргүүлэх. (шаардлагатай тохиолдолд)



## ХУУЛИЙН ШАТ ДАМЖЛАГА

### **Алхам 6:** НЭГДЭЖ ОРСОН ТУХАЙ МЭДЭГДЭЛ (? сар)

1. Нэгдэж орсон тухай мэдэгдлийг бэлтгэх;
2. Мэдэгдлийг ОУДБ-ын ЕНБ-д хадгалуулах;
3. ОУДБ-д тайлан хүргүүлэх үүрэг хүлээх.

### **Алхам 7:** ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ & СУРГАЛТ СЕМИНАР (? сар)

1. Тараах материал гаргах & хэвлэл мэдээллээр сурталчлах;
2. Холбогдох талуудтай хамтран сургалт семинар зохион байгуулах;
3. Хэрэгжүүлж ажиллах ажилтанууддаа зориулан дотоод сургалт явуулах;
4. Далайчдад зориулан гаргадаг сургалтын материал, баримт бичгийг тухайн шинэ хуулийн шаардлагад нийцүүлэн өөрчлөх.

## ХУУЛИЙН ШАТ ДАМЖЛАГА

Дээрх шат дамжлагууд дараах бүх конвенцид хамааралтай. (SOLAS 1974, MARPOL 73/78, LL 66, гм)

- Түүнчлэн эдгээр хуулийг хэрэгжүүлэх, мөрдүүлэхэд гарын авлага, зөвлөмж, зааварчилгаа гээд нэмэлт баримт бичгийг боловсруулан гаргах шаардлагатай. Ялангуяа хууль бүрт тусгайлан тодорхойлох хэв хэмжээг үлдээсэн дараахь шаардлагууд байдаг. Үүнд:
  - Захиргааны шаардлага (satisfaction of Administration)
  - Үзлэг хяналтыг явуулах байцаагчдын ашиглах зааварчилгаа
  - Үзлэг хяналтыг явуулах процесс, үзлэгийг хэрэгжүүлэх ба гэрчилгээжүүлэх зааварчилгаа
  - Хөнгөлөх, адилтган үзэх/орлуулах болон үүрэг хариуцлагаас чөлөөлөх нөхцөл шаардлагыг тодорхой тусгах гм (Procedures/criteria for granting of exemptions/equivalents/dispensations etc.)

## ХУУЛИЙН ШАТ ДАМЖЛАГА

Жишээ нь “А” Улсын хувьд:

- ▶ Аливаа нэг конвенцийн нарийвчилсан, техникийн шаардлага нь төрөл бүрийн журам, зарлиг, тушаал гэх мэт дагалдах хууль дүрэм хэлбэрээр батлагдсан байх;
- ▶ торгууль, шийтгэлтэй холбоотой зохицуулалтыг гол хуулиндаа (далайн салбарын бус) тусгаж өгсөн байж болох ба эдгээр нь хууль зөрчихөөс сэргийлж чадахуйц (санхүүгийн болон цагдан хорих г.м.) чанга хатуу нөхцөлтэй байх шаардлагатай.

## ХУУЛИЙН ШАТ ДАМЖЛАГА

### Жишээ нь “В” Улсын хувьд:

Гол салбарын хуулиндаа шууд конвенц руу чиглүүлсэн заалтуудыг оруулсан байж болох бөгөөд энэ тохиолдолд үндэсний хууль тогтоомжид дараахь заалтууд заавал тусгагдсан байна. Үүнд:

- Улсын байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн үүрэг хариуцлага;
- Хуулийг мөрдүүлэх, албадан хэрэгжүүлэх заалтууд;
- Өөрийн улсын хууль эрх зүйн хүрээнд тохируулан буулгасан заалтууд;
- Өөрийн улсын эрх үүргийг хэрэгжүүлэх нөхцөл, эдгээрт тавигдах шаардлага (заавал тусгаж өгөх шаардлагатай гэж үзвэл);
- Торгууль, шийтгэлийн заалтууд байна.

## ХУУЛИЙН ШАТ ДАМЖЛАГА

“А” болон “Б” улсуудын хууль эрх зүйн орчны давуу болон сөрөг тал нь ямар байх вэ?

Давуу тал нь юу байх вэ?

Дутагдалтай тал нь юу байх вэ?

## ОЛОН УЛСЫН ДАЛАЙН СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ГОЛ ТОГЛОГЧ НЬ ХЭН БЭ?

- ▶ ОУДБ нь далайн тээврийн техникийн аюулгүй байдал, байгаль орчныг бохирдуулахаас сэргийлсэн стандартыг болорвсруулах үүрэг хариуцлага бүхий ОУ-ын байгууллага юм.
- ▶ ЗАСГИЙН ГАЗАР нь эдгээр стандартыг хэрэгжүүлэх, мөрдүүлэх, албадан хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.
- ▶ Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага (RO)-ууд нь далбааны эзэн улсын хүлээх шаардлагатай үүрэг хариуцлагын зөвхөн тодорхой хэсгийг л хариуцна.
- ▶ Далайн тээврийн компаниуд нь эдгээр стандартуудыг хөлөг онгоц бүрт нэвтрүүлэх, хэрэгжүүлэн ажиллах, шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.
- ▶ Хөлгийн тавцан дээр ажиллаж буй хүмүүс эдгээр аюулгүй байдлын болон бохирдлын эсрэг арга хэмжээнүүдийг хөлөг онгоцон дээр хэрэгжүүлж ажиллах үүрэг хүлээнэ.
- ▶ Талууд нь аливаа нэгэн конвенцийн үүрэг хариуцлагыг ухамсарлан, хүлээн зөвшөөрч нэгдэж орсноор тухайн Олон Улсын хуулийн заалтад тусгагдсан арга хэмжээг шат бүрт тохируулан хэрэгжүүлж, биелэлтийг хангах ажлыг зохион байгуулна.

## ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ

Далбааны эзэн Улс нь Олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу зохицуулах болон хэрэгжилтийг хянах, хуулийг мөрдүүлэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

- Өөрийн далбаатай хөлөг онгоцон дээр тухайн нэгдэж орсон конвенцийг таниулах мөрдүүлэх, хэрэгжилтийг хянах системийг бий болгох;
- Тухайн хуулийг хэрэгжүүлж ажиллахад чиглэгдсэн дүрэм журмыг батлах.

Ихэнх гэрээ конвенцуудад дараахь нэр томъёо болон уялдан гарах шаардлагуудыг тухайн Засгийн газарт боловсруулж мөрдүүлэх үүргийг хуульчилсан байдаг. Үүнд:

- Захиргаанаас хангалттай гэж үзэх шаардлагыг тодорхойлох;
- Хөнгөлөх, адилтган үзэх/орлуулах болон үүрэг хариуцлагаас чөлөөлөх нөхцөл шаардлагыг тодорхой тусгах
- Захиргааны өмнөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд баримтлах эрх мэдлийн хязгаарлалтын хэмжээ

## ОУДБ-ЫН ЗҮГЭЭС ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХЯНАЛТ ТАВИХГҮЙ.

ОУДБ-ын конвенц нь тухайн хууль тогтоомжийг мөрдүүлэх болон хэрэгжилтийг хянах тухай ямар нэгэн эрх мэдлийг ОУДБ-д аливаа зүйл заалтаар олгоогүй.

- ▶ Аливаа Гишүүн Улс нэгдэж орсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн биелүүлж байгааг ажиглах, хариуцлага тооцох өөрийн гэсэн системтэй болох шаардлага ОУДБ-д тулгарсан.
- ▶ Хэрхэн энэхүү хяналтыг хэрэгжүүлэх вэ гэдэг шийдэл аажмаар үүсэн бий болж байна.



## ОУДБ-ЫН АУДИТЫН ШАЛГАЛТЫН ҮҮССЭН ЯВЦ

2005 онд хуралдсан ОУДБ-ын 24 дүгээр чуулганаар САЙН ДУРЫН АУДИТЫН ШАЛТГАЛТ явуулах тухай тогтоолыг баталсан ба энэхүү үйл ажиллагаа нь 2005-2013 оны хооронд амжилттай хэрэгжсэн.

А.974(24) дугаартай тогтоолоор тус аудитын үйл ажиллагааг хамрах хүрээ болон хэрэгжүүлэх арга хэрэгсэл, явцыг хуульчлан баталсан.

А.973(24) Тогтоолоор Заавал хэрэгжүүлэх шаардлагатай олон улсын далайн байгууллагын хууль тогтоомжийн тухай баримт бичгийг баталсан.

Энэхүү арга хэмжээнд 79 гишүүн болон дагалдагч гишүүн (associate member) орон оролцсон бол нийт 59 гишүүн орон, 2 дагалдах гишүүн орон болон 5 харьяаллын бүс нутаг бүхий улс орон шалгуулав.

# ОУДБ-ЫН АУДИТЫН ШАЛГАЛТЫН ҮҮССЭН ЯВЦ

2009 оны 26 дугаар Ассемблей

Заавал хэрэгжүүлэх Аудитын шалгалтын тухай

2010 - 2015

Тогтоол А.1018(26)

Шинэчлэн гаргасан хууль ОУДБ-ын Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл

(III Code)

8 конвенцийн хэрэгжилтийг хангах

Шинэчлэн өөрчлөгдсөн хуулийн хүрээ болон хэрэгжүүлэх явц

Аудиторын гарын авлага

(Circular letter No.3425)

# ОУДБ-ЫН АУДИТЫН ШАЛГАЛТЫН ҮҮССЭН ЯВЦ

2013 оны 28 дугаар Ассемблей

Гишүүн орнуудад хэрэгжүүлэх Аудитын шалгалтын хамрах хүрээ болон явцын тухай (A.1067(28) Тогтоол )

2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжсэн

Сайн дурын аудитын шалгалтаас Заавал хийгдэх хуваарьт аудитын шалгалтанд шилжих тухай (A.1068(28) Тогтоол)

19

ОУДБ-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэрэгслийн тухай (III) Code A.1070(28)

Resolutions A.1083 (28), A.1084 (28) and A.1085 (28)

## АУДИТЫН ШАЛГАЛТЫН СТАНДАРТ

### Сайн дурын аудит буюу VIMSAS нь

2006 – 2013 онд ОУДБ-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл

Хамрах хүрээ болон хэрэгжүүлэх арга хэрэгсэл, явц

А.974 (24) дугаар тогтоолоор батлагдан хэрэгжиж байсан.

### Сайн дурын Аудитаас Заавал хамрагдах аудит руу шилжих завсрын үед

2013 оны 28 дугаар Ассемблейн хуралдаанаар Гишүүн орнуудад хэрэгжүүлэх Аудитын шалгалтын хамрах хүрээ болон явцын тухай (А.1067(28) Тогтоол ) баримт бичгийг баталсан байна.

Заавал хамрагдах аудитын үед ч мөн энэхүү баримт бичиг хүчин төгөлдөр үйлчилж байна.

# ЗААВАЛ ХЭРЭГЖИХ АУДИТЫН ХҮРЭЭНД

2016 оны нэгдүгээр сард аудитын шалгалт хийхэд зориулан ихэнх конвенцид дараахь нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

## Конвенцууд

## Нэмэлт өөрчлөлт

SOLAS 1974

Далайн аюулгүй байдлын хорооны тогтоол MSC.366(93)

MARPOL

Далайн байгаль орчны хорооны тогтоол MEPC.246(66) – Хавсралт I - V , тогтоол MEPC.247(66) – Хавсралт VI

STCW 1978

Далайн аюулгүй байдлын хорооны тогтоол MSC.373(93), MSC.374(93) - STCW Code

LL 66

A.1083(28) тогтоол

LL PROT 1988

Далайн аюулгүй байдлын хорооны тогтоол MSC.375(93)

Tonnage 1969

A.1084(28) тогтоол

COLREG 1972

A.1085(28) тогтоол

## 2015 ОНЫ А.1105(29) ТОГТООЛООР ОУДБ-ЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ЗААВАЛ БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН ХУВААРИЙГ ГАРГАВ.

Хавсралт 1	Гишүүн орнуудын (Засгийн газрын) үүрэг
Хавсралт 2	Далбааны эзэн Улсын хүлээх тодорхой үүрэг, хариуцлага
Хавсралт 3	Эргийн Улсын хүлээх тодорхой үүрэг, хариуцлага
Хавсралт 4	Боомтын Улсын хүлээх тодорхой үүрэг, хариуцлага
Хавсралт 5	Заавал хэрэгжүүлэх шаардлагатай ОУДБ-ын хууль тогтоомжууд
Хавсралт 6	Заавал хэрэгжүүлэх шаардлагатай хууль тогтоомжийн эрх үүргийн хариуцлагын хуваарьт орсон нэмэлт өөрчлөлтүүдийн тойм (Хавсралт 1-4)
Хавсралт 7	2016.01.01-2016.07.01 хүртэлх хугацаанд батлагдахаар болон хүчин төгөлдөр болж үйлчлэхээр хүлээгдэж байгаа ОУДБ-ын хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтүүд

## АУДИТААР ШАЛГАГДАХ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ (ОУК)-ИЙН ЖАГСААЛТ

Дараахь 9 хуулийн хэрэгжилтийг Аудитын хуваарьт шалгалтын үеэр шалгана. Үүнд:

1. Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай ОУК (SOLAS 1974)
2. Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай ОУК (SOLAS PROTOCOL 1988)
3. Далайг хөлөг онгоцноос бохирдуулахын эсрэг (MARPOL 73/78)
4. Далайг хөлөг онгоцноос бохирдуулахын эсрэг (MARPOL PROTOCOL 1997)
5. Далайчныг сургах стандарт, гэрчилгээ олгох болон ээлжийн ажиллагааны тухай (STCW 1978)
6. Даацын тэмдэглээний тухай 1966 оны ОУК (LOAD LINES 1966) (LL66)
7. Даацын тэмдэглэгээний тухай ОУК-ийн 1988 оны протокол (LL 66 PROT 1988)
8. Хөлөг онгоцны багтаамжийн хэмжилтийн тухай 1969 оны ОУК (TONNAGE 1969)
9. Далайд хөлөг онгоц мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх ОУ журмын тухай (COLREG 1972)

## АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШАТЛАЛ

Аудитын үйл ажиллагааны хамрах хүрээг тодорхойлохдоо:

- ▶ Аудитыг зохион байгуулах зорилго, аудитын үеэр баримтлах зарчим,
- ▶ далайц,
- ▶ хүний нөөцийн чадавхи болон хүн тус бүрийн хариуцах ажил үүргийг хамруулах ба энэхүү үйл ажиллагааны хамрах хүрээ нь тухайн аудитын стратегийн зорилт болох юм.

Үйл ажиллагааны хамрах хүрээ нь ОУДБ-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл буюу III Кодийг хэрэгжүүлэх явцад илүү ойлгомжтой тодорхой болно.



# ОУДБ-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл (III Code)

- ОУДБ-ын 28 дугаар Ассемблейн А.1070(28) дугаартай тогтоолоор батлагдсан.
- III Кодын зорилго:
  - Дэлхий нийтийн далайн тээврийн аюулгүй байдлыг сайжруулах болон байгаль орчныг далайн тээврийн хэрэгслээс бохирдуулахаас хамгаалах;
  - ОУДБ-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд гишүүн орнуудад тусламж дэмжлэг үзүүлэх;
  - Аудитын шалтгалтын нэгдсэн стандартыг тогтоох;
  - Гишүүн орнуудын хэрэгцээнд ашиглагдах гарын авлага болгох.

## СТРАТЕГИ (3 ДУГААР ПАРАГРАФ)

Аливаа гишүүн орон нь:

- Олон Улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа бүрэн хүлээж, түүнийг биелүүлэх зорилтыг агуулсан ерөнхий стратегийг боловсруулах үүрэгтэй.
- Тэрхүү боловсруулсан стратеги нь олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд хангалттай арга хэрэгсэл болж чадаж байгаа эсэхэд хяналт тавьж дүгнэх механизмийг тодорхойлох шаардлагатай.
- Байгууллагын гүйцэтгэл, чадавхи тухайн стратегийг хэрэгжүүлэхэд хүрэлцэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж цаашид хэрхэн сайжруулах тал дээр ажиллах ёстой.

# ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА ХОЛБОО

ОУДБ-ын англи хэл дээрх презентацийн 26 дугаар хуудсанд байх схем, зураглалыг харна уу.

## НИЙТЛЭГ ЗҮЙЛС

III Кодын 1 дүгээр хэсэг, 8 дугаар параграфт тусгагдсан.

► Эхлэх үе шат:

Аливаа нэгэн конвенцид нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд Засгийн газрын зүгээс тухайн шинэ зохицуулалттай уялдсан заалтуудыг өөрийн улсын холбогдох хууль тогтоомждоо суулган хэрэгжүүлэхэд шаардлагатай механизмыг бүрдүүлнэ.

- Хуулийг түгээн дэлгэрүүлж таниулах, хэрэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэх боломжтой байх.
- Хөлөг онгоцыг бүртгэх хууль эрх зүйн үндэс, тавигдах ерөнхий шаардлагуудыг тодорхойлох, хөлөг онгоцны үзлэг шалгалт, үндэсний хууль тогтоомжинд тусгагдсан байх ба үүнд мөрдөн шалгах болон хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бүрэн шийдвэрлэж оруулсан байна.
- Үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах улмаар зарим конвенцид тусгагдсан тайлан мэдээг хариуцан ажиллах хангалттай хүний нөөц, мэргэжлийн боловсон хүчинтэй байх шаардлагатай.

## ДАЛБААНЫ ЭЗЭН УЛСЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА (III код, 2 дугаар хэсэг)

- **Далбааны эзэн улсын эрх үүргийг хэрэгжүүлэх;**
- Хүлэн зөвшөөрөгдсөн байгууллага (RO)-г томилох;
  
- **Далбааны эзэн улсын эрх үүргийг албадан хэрэгжүүлэх;**
- Далбааны эзэн улсын үзлэг хийх үзлэг хяналтын байцаагчид;
- Далбааны эзэн улсын үзлэг хяналтыг хийх;
- Үнэлэлт дүгнэлт өгөх, гарсан алдаа дутагдлыг хянаж үзэх.

## ДАЛБААНЫ ЭЗЭН УЛСЫН ЭРХ, ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

III Кодын 15-17 дугаар параграфт тусгагдсан үйл ажиллагааг хамруулан ойлгоно.

- ▶ ОУДБ-ын заавал хэрэгжүүлэх шаардлагатай өгөгдсөн хууль тогтоомжийг жагсаалтыг ашиглаж өөрийн улсын дүрэм журамтай харьцуулан шалгана. Үүнд:
  - ▶ Дүрэм журам → бодлогын баримт бичиг → хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага → шаардагдах нөөц боломж, хөрөнгө болон хэрэгжүүлэх процесс → хэрэгжилт
  - ▶ Далай дахь хүний аюулгүй байдлыг хангах болон байгаль орчныг бохирдлоос сэргийлэхэд чиглэгдсэн зохих арга хэмжээг авах хангалттай нөөц боломжийг бүрдүүлэх шаардлагатай бөгөөд ийм төрлийн хөтөлбөрийг дотоод менежментийн системийн нэг хэсэг болгох замаар хөгжүүлж болох юм.
  - ▶ Олон Улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд Захиргаанаас зааварчилгаа гаргах эсхүл тухайн хууль тогтоомжийг үндэсний хууль тогтоомжиндоо заавал оруулах шаардлагатай байж болно.

## ДАЛБААНЫ ЭЗЭН УЛСЫН ЭРХ, ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

III Кодын 15-17 дугаар параграфт тусгагдсан үйл ажиллагааг хамруулан ойлгоно.

- Энэхүү кодын 16.5 дугаарт тусгагдсан “Захиргаанаас тавигдах шаардлагыг хангах” тухай зохицуулалтыг хууль тогтоомж/дүрэм/бодлого болон үйл ажиллагаандаа зайлшгүй хуульчан оруулах шаардлагатай.
- Далайчныг сургах стандарт, гэрчилгээ олгох болон ээлжийн ажиллагааны тухай конвенцийг энэхүү хуулийн хүрээнд тодорхой хязгаарлалтын дагуу зохицуулна. Энэхүү конвенцийн Кодыг ОУДБ-ын MSC.374(93) дугаартай тогтоолоор баталсан бөгөөд холбогдох нэмэлт өөрчлөлтөд тухайн хязгаарлалтад шаардагдах асуултуудыг оруулсан.

## АЛБАДАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГУУД

III Кодын 22-27 дугаар параграфт тусгагдсан үйл ажиллагааг дараахь арга хэмжээг хэрэгжүүлсэний үндсэн дээр хэрэгжинэ.

1. Аливаа хөлөг онгоц нь ОУ-ын бүх шаардлагад нийцсэн гэдгийг нотлохоос өмнө өөрийн улсын далбаан дор аялахыг хориглох системтэй байх;
2. Өөрийн улсын далбаан дор аялж яваа хөлөг онгоцыг өөрийн болон бусад улсын боомт дээр үе үе шалгалтанд хамруулж хэвших;
3. Хөлөг онгоцыг удирдаж буй багийн гишүүд хангалттай сургагдаж бэлтгэгдсэн гэдгийг сайтар шалгаж үзсэн байх;
4. Тухайн улсын далбаан дор аялж яваа аливаа нэгэн хөлөг онгоцны эзэмшигч, оператор, эсхүл багийн гишүүн нь тус улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ гажуудуулсан, эсхүл зөрчсөн болох нь үзлэг хяналтын явцад тогтоогдсон нөхцөлд ноогдуулах торгууль болон бусад хариуцлагын системийг тодорхой болгох, ийм системийг цогцоор нь хөгжүүлэх;
5. Тогтмол хянах болон шалгах систем бүхий тодорхой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
6. Үндэсний хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэх, мөрдлөг болгон ажиллах мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн сайтар бэлтгэгдсэн багтай байх;
7. Тухайн Улсын далбаан дор аялж буй хөлөг онгоцыг боомтын эргийн хяналтаас саатуулагдсан тохиолдолд холбогдох арга хэмжээг авч ажиллах системтэй болсон байх.



## АЛБАДАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГУУД

III Кодын 22-27 дугаар параграфт тусгагдсан үйл ажиллагаанд хамаарна.

Албадан хэрэгжүүлэх арга хэмжээ нь үндэсний хууль тогтоомжид тусгагдсан байхаас гадна дараахь эрх үүргийг хариуцан хэрэгжүүлдэг байгууллага, хувь хүнд эрхийг хуулиар олгож өгсөн байна. Үүнд:

- ▶ Аливаа хөлөг онгоцны тавцан дээр гарч эд анги, тоног төхөөрөмжийг шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд;
- ▶ Хөлөг онгоцон дээр гарч хөлгийн журнал болон холбогдох гэрчилгээ баримт бичгийн бүрдэлийг шалгах эрх бүхий байгууллага, хуулийн этгээд;
- ▶ Хөлөг онгоцыг саатуулах эрх бүхий байгууллага, хуулийн этгээд;
- ▶ Хөлгийн эх биеийг үзэх зорилгоор хөлөг онгоцыг зориулалтын зогсоолд очиж зогсохыг шаардах эрх бүхий албан тушаалтан.

## АЛБАДАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГУУД

III Кодын 22-27 дугаар параграфт тусгагдсан үйл ажиллагаанд хамаарна.

- ▶ Албадан хэрэгжүүлэх хуулийн зохицуулалт нь зөвхөн Далай ашиглах тухай хууль, түүнийг дагалдан гарсан дүрэм журамд баригдахгүй байхаар зохицуулна.
- ▶ Зарим тохиолдолд Иргэний болон Эрүүгийн хуулийн зүйл, заалтууд ч үйлчлэхүйц байхаар хуулиндаа зааж өгөх шаардлагатай.
- ▶ Зарим албадан хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Аудитын хүрээнд үл хамаарах Засгийн газрын бусад агентлаг, нэгжүүдийн зүгээс ч хийгдэж болно.
- ▶ Танай далайн захиргаа, удирдлага өөрийн чиг үүргийн хүрээнд ямар нэгэн Албадан хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий мэргэжлийн агентлагт мэдээлэл цуглуулж өгөх, бэлтгэн боловсруулж өгөх үүрэг хариуцлагыг хүлээсэн ямар нэгэн систем байгаа эсэх?

## АЛБАДАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГУУД

Хэрэг мөрдөх үйл ажиллагаа:

1. Холбогдох хууль тогтоомж зөрчигдсэн тохиолдолд хэргийг мөрдөн шалгах шаардлагатай эсэхэд анхаарал хандуулан хянаж үзнэ.
2. Хэрэг мөрдөлт явуулах эсэх шийдвэрийг гарах нөхцөл байдал нь хууль зөрчсөн үйл ажиллагааны ерөнхий шинж чанараас хамаарна.

## ЭРГИЙН УЛСЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Эргийн улсын аудитын үйл ажиллагааны цар хүрээг III Кодын 3 дугаар хэсгийн 45-51 дүгээр параграфт тусгагдсан. Үүнд:

- Хуулийг хэрэгжүүлэх;
- Албадан хэрэгжүүлэх;
- Үнэлгээ дүгнэлт өгөх, эргэн харах, засаж сайжруулах.

## ЭРГИЙН УЛСЫН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Үндэсний хууль тогтоомж, холбогдох гарын авлага, зааварчилгаагаар дамжуулан Үндэсний далайн тээврийн бодлогыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ▶ Радио холбооны үйлчилгээ
- ▶ Цаг агаарын мэдээний үйлчилгээ болон анхааруулах үйл ажиллагаа
- ▶ Эрэн хайх авран туслах үйл ажиллагаа
- ▶ Ус цаг уурын үйлчилгээ
- ▶ Хөлөг онгоцны зам маршрутыг заах үйлчилгээ
- ▶ Хөлөг онгоцны мэдээ мэдээллийн систем
- ▶ Хөлөг онгоцыг даган хянах систем
- ▶ Жолоодлогын туслалцаа үзүүлэх үйлчилгээ

## БООМТЫН ЭЗЭН УЛСЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Боомтын эзэн улсын үйл ажиллагааны цар хүрээг III Кодын 4 дүгээр хэсгийн 52-63 дугаар параграфт тусгагдсан.

- Хуулийг хэрэгжүүлэх
- Албадан хэрэгжүүлэх
- Үнэлгээ дүгнэлт өгөх, эргэн харах, засаж залруулах

# БООМТЫН УЛСАД ШААРДЛАГАТАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

Боомтын Эзэн Улс нь дараахь үндэсний хууль тогтоомж, гарын авлага, зөвлөмжөөр дамжуулан үндэсний бодлогыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ▶ Эрх үүрэг болон хариуцлагын хуваарилалт;
- ▶ Боомтын ачаа барааг хүлээн авах тоног төхөөрөмжийн тухай заалтууд
- ▶ Боомтын Хяналтын Алба
- ▶ Газрын тос ханган нийлүүлэгчдийн бүртгэл
- ▶ Аюултай ачаа бараатай ажиллах зааварчилгаа
- ▶ Нурмаг ачаа барааг ачих, буулгах г.м.
- ▶ Албадан хэрэгжүүлэх зүйл заалтууд
- ▶ Боомтын эргийн хяналтын системийг бий болгох, хэрэгжүүлэх, ажиллуулах, хянах

## ОУДБ-ЫН АУДИТЫН ШАЛГАЛТЫН ТАЙЛАНГИЙН ЕРӨНХИЙ ЖИШЭЭ

ОУДБ-ын англи хэл дээрх презентацийн 39, 40 дүгээр хуудаснаас ОУДБ-ын Аудитын шалгалтын дүнд илэрсэн Алдаа дутагдал болон Ажиглалтын ерөнхий жишээг харж болно.



## ИЛТГЭГЧ ОУДБ-ЫН АЖИЛТАН MS. TATJANA KRILIC



4 Albert Embankment London SE1 7SR  
United Kingdom

Tel: +44 (0)20 7735 7611 Fax: +44 (0)20  
7587 3210 Email: [info@imo.org](mailto:info@imo.org)

International Maritime Organization

DEPT. MSA&IS MARITIME SAFETY  
DIVISION

[twitter.com/imohq](https://twitter.com/imohq) [facebook.com/imohq](https://facebook.com/imohq)  
[youtube.com/imohq](https://youtube.com/imohq) [flickr.com/photos/  
imo-un/collections](https://flickr.com/photos/imo-un/collections)

[www.imo.org](http://www.imo.org)